

75-с дээш насны гадаад иргэн корона19-с урьдчилан сэргийлэх

тарилга хийлгэх заавар

- **Вакцинжуулалтанд хамрагдах хүн** : БНСУ-д удаан хугацаагаар (90 хоногоос дээш хугацаагаар) оршин сууж буй 75 ба түүнээс дээш насны (1946 оны 12-р сарын 31-ээс өмнө төрсөн) гадаадын иргэд
- **Вакцины төрөл** : Comirnaty (Pfizer/BioNTech) COVID-19 vaccine
  - ※ 21 хоногийн зайтай 2 удаа тарина.
- **Вакцин хийлгэх газар** : Орон нутаг засаг захиргааны(Хот, сум, дүүрэг) Корона19 вакцинжуулалтын төвүүд
  - ※ Бүс нутгаас хамаарч вакцинжуулалт эхлэх хугацаа нь харилцан адилгүй байх тул вакцин хийлгэх хүсэлт гаргах үед тусгайлан мэдэгдэнэ.
- **Вакцинжуулалтанд хамрагдах дараалал**
  - ① **Вакцин хийлгэх хүсэлт гаргах (4~6 сар)** : Тосгон, баг, хорооны иргэдэд үйлчлэх төвд очин вакцин хийлгэхийг зөвшөөрсөн хуудсаа өгнө. (заавал биечлэн очих)
    - ※ Гадаадын иргэний бүртгэлийн дугааргүй урт хугацааны оршин суугч болон гадаад иргэний бүртгэлээс чөлөөлөгдсөн гадаадын иргэн (ГЦагаачлалын тухай хуулийн 31-р зүйлийн 1-р хэсэг) эрүүл мэндийн төвөөс түр бүртгэлийн дугаар(паспорт зэрэг биеийн байцаалтаа авч очих) хүлээн авсны дараа тосгон, баг, хорооны иргэдэд үйлчлэх төвд вакцин хийлгэх хүсэлт гаргах боломжтой.
  - ② **Вакцин хийлгэх огноог баталгаажуулах** : Тосгон, баг, хорооны иргэдэд үйлчлэх төвдөөс утсаар ярих, мессеж илгээх гэх мэтээр мэдэгдэнэ.
  - ③ **Вакцин хийх** : Вакцин хийлгэхээр тогтсон өдөр, цагтаа вакцинжуулалтын төвд очиж эхний вакцинаа хийлгээд, 21 хоногийн дараа дахин очиж хоёр дахь удаагийн вакцинаа хийлгэнэ.
    - ※ Заавал биеийн байцаалтаа авч очно уу.
  - ④ **Вакцин хийлгэсний дараа анхаарах зүйл** : Вакцин хийлгэснээс хойш дор хаяж 3 хоногийн турш эрүүл мэндийн байдлаа анхааралтай ажиглана уу.
    - ※ Хэрэв халуурах эсвэл булчин өвдөх зэрэг шинж тэмдэг илэрч энэ нь 3-аас дээш хоног үргэлжилбэл эмнэлгийн байгууллагад хандан эмчилгээ хийлгэх, ноцтой харшлын шинж тэмдэг илэрвэл яаралтай түргэн тусламжийн тасагт очиж үзүүлнэ үү.
- **Лавлах утас**
  - Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх газрын дуудлагын төв ☎1339 (Гадаад хэлээр мэдээлэл авах боломжтой)
  - Оршин сууж буй тосгон, баг, хорооны иргэдэд үйлчлэх төв

<Энэхүү орчуулгыг Данүри төв 1577-1366 хийсэн болно>